



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ

2017 оны 9 дүгээр сар

Ерөнхий тойм: Энэ оны эхний 9 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 33.4%-иар буюу 1933 сая ам.доллараар өсч, 7,714 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 38%-иар буюу 1,250 сая ам.доллараар, импорт 28%-иар буюу 683 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 1,452 сая ам.доллараар давснаар гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 567 сая ам.доллараар өссөн байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 9 сар			Өөрчлөлт			
	2014	2015	2016	2015/2014		2016/2015		2015	2016	2017	2016/2015		2017/2016	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	11,011	8,467	8,274	(2,544)	-23.1%	(192)	-2.3%	6,398	5,780	7,714	(617)	-10%	1,933	33.4%
Экспорт	5,774	4,669	4,916	(1,105)	-19.1%	247	5.3%	3,541	3,332	4,583	(209)	-6%	1,250	38%
Импорт	5,237	3,798	3,358	(1,439)	-27.5%	(439)	-11.6%	2,857	2,448	3,131	(409)	-14%	682.8	28%
Тэнцэл	538	872	1,558	334		686	78.7%	684	884	1,452	200	29%	568	64%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2017 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 1,582 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 693 сая ам.доллараар өссөн байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 64.2% буюу 4951.8 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 12.3% буюу 947 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. БНХАУ-тай хийсэн худалдаа өнгөрсөн оны мөн үеэс 40.2%-иар, ОХУ-тай хийсэн худалдаа 44.1%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс тайлант хугацааны эцэст өмнөх оны мөн үеэс 40%-иар өссөн бол, өмнөх сараас 2%-иар буурч 1.68-д хүрлээ. Тайлант сард хөрөнгө оруулалт болон хэрэглээний барааны импортын үнэ өссөнөөс голлон шалтгаалж худалдааны нөхцөл өмнөх сараас муудсан.

Экспорт 2017 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 38%-иар букуу 1,250 сая ам.доллараар өсөв. Уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт нь нийт экспортыг 37.1 нэгж хувиар, уул уурхайгаас бусад төрлийн экспорт нь нийт экспортыг 0.5 нэгж хувиар өсөхөд нөлөөлжээ. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 4 нэгж хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний эзлэх хувь 3 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		3,080	87%	2,808	84%		4,044	88%		(271)	-9%	-8%	1,236	44%	37.1%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,060	1,715	48%	1,198	1,272	38%	1,084	1,155	25%	(443)	-26%	-13%	(117)	-9%	-4%
1.2. Чулуун нүүрс	10,458	432	12%	16,074	506	15%	25,532	1,724	38%	73	17%	2%	1,219	241%	37%
1.3. Боловсруулагүй нефть	5,857	293	8%	5,877	235	7%	5,636	272	6%	(58)	-20%	-2%	37	16%	1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	3,424	164	5%	4,581	178	5%	4,309	228	5%	13	8%	0%	51	29%	2%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	7,581	286	8%	9,849	399	12%	9,883	403	9%	113	40%	3%	3	1%	0%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	78	96	3%	98	107	3%	91	134	3%	11	12%	0%	27	25%	1%
1.7. Жоноц лейцит, нефелинт	202	47	1%	187	45	1%	216	55	1%	(2)	-4%	0%	10	22%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3	23	1%	4	18	1%	5	27	1%	(5)	-21%	0%	9	52%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	11	0%	1	8	0%	1	5	0%	(3)	-31%	0%	(2)	-32%	0%
1.10. Мөнгө /тонн/	54	10	0%	68	28	1%	0	1	0%	18	1%		(28)	-98%	-1%
1.11. Бусад	48	1	0%	70	12	0%	264	39	1%	11	746%	0%	27	1%	1%
2. Мал аж, ахуй		278	8%	259	8%		312	7%		(19)	-7%	-1%	53	20%	1.6%
2.1. Амьд мал, малын мах	2	7	0%	4	9	0%	14	26	1%	2	28%	0%	17	189%	1%
2.2. Арьс, шир	220	23	1%	120	17	1%	216	17	0%	(6)	-25%	0%	(0)	-1%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	7	0%	0	5	0%	0	5	0%	(2)	-30%	0%	0	0%	0%
2.4. Ноолуур	6	226	6%	6	211	6%	7	244	5%	(16)	-7%	0%	33	16%	1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	10	14	0%	11	16	0%	13	18	0%	2	13%	0%	2	15%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	1	0%	1	2	0%	0	80%	0%	1	115%	0%
3. Газар тариалан		21	1%	13	0%		9	0%		(9)	-40%	0%	(4)	-34%	-0.1%
4. Аж үйлдвэрлэл		160	5%	252	8%		217	5%		92	57%	3%	(34)	-14%	-1.0%
4.1. Хүнс	2	16	0%	5	24	1%	16	65	1%	8	49%	0%	41	169%	1%
4.2. Ноолууран эдлэл	0	18	1%	0	18	1%	0	21	0%	0	2%	0%	3	17%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	0	7	0%	1	11	0%	2	12	0%	4	63%	0%	1	8%	0%
4.4. Уул уурхай	30	62	2%	22	61	2%	26	80	2%	(1)	-1%	0%	19	31%	1%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	2	0%	0	4	0%	0	1	0%	2	129%	0%	(3)	-83%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, ад анги	1	51	1%	1	126	4%	1	34	1%	76	149%	2%	(92)	-73%	-3%
4.7. Бусад	167	5	0%	179	7	0%	288	5	0%	2	45%	0%	(2)	-31%	0%
5. Бусад		2	0%	1	0%		1	0%		(1)	-61%	0%	(0)	-15%	0.0%
Нийт дүн		3,541		3,332			4,583			(209)	-6%		1,250	38%	


%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2017 он

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	520.5	42%	715.6	58%	1,236	44%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(121.1)	104%	4.2	-4%	(116.9)	-9%
1.2. Чулуун нүүрс	638.7	52%	580.0	48%	1,219	241%
1.3. Боловсруулагүй нефть	(11.7)	-31%	49.0	131%	37	16%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	(14.4)	-28%	65.1	128%	50.7	29%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	1.4	40%	2.1	60%	3.5	1%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(10.5)	-39%	37.1	139%	26.6	25%
1.7. Жоноц лейцит, нефелинт	7.3	73%	2.7	27%	9.9	22%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	4.4	47%	5.0	53%	9.4	52%
1.11. Бусад	28.7	106%	(1.7)	-6%	27.0	0%
2. Мал аж, ахуй	51.3	97%	1.8	3%	53.1	20%
2.2. Арьс, шир	7.6	-4478%	(7.8)	4578%	(0.2)	-1%
2.4. Ноолуур	23.7	72%	9.3	28%	33.0	16%
3. Газар тариалан	(0.5)	12%	(3.8)	88%	(4.4)	-34%
4. Аж үйлдвэрлэл	75.1	-220%	(109.3)	320%	(34.2)	-14%
5. Бусад	(0.0)	23%	(0.1)	77%	(0.1)	-15%
Нийт дүн	646.3	52%	604	48%	1,250	38%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2017 оны эхний 9 сарын гүйцэтгэл нь экспортын гадаад худалдаа тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 646.3 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 604 сая ам.доллараар өссөн байна. Уул уурхайн түүхий эдийн экспорт нүүрсний экспортын биет хэмжээ, үнэ өссөнөөс шалтгаалж 1,236 сая ам.доллараар өссөн байна. Харин мал аж, ахуйн түүхий эдийн экспорт үнэ, тоо хэмжээний аль аль нь нэмэгдсэнээс шалтгаалж 53.1 сая ам.доллараар өсжээ. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөн хэдий ч үнэ буурсанаас шалтгаалж 34.2 сая ам.доллараар буурсан байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2017 оны 9 дүгээр сард 1,315 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.8%-иар буурсан, өнгөрсөн сараас 2.4%-иар өссөн байна. "А" зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,577, 71.5 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 39.3%-иар, төмрийн хүдэр 23.4%-иар тус тус өссөн, өнгөрсөн сараас зэс 1.4% өсч, төмрийн хүдэр 6%-иар буурсан байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 9 дүгээр сард 67.6 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 93.8%-иар өссөн бол өмнөх сараас 2.4%-иар буурсан байна.

Импорт 2017 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 27.9%-иар буюу 683 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангилалаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 15 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний өсөлт 10 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний өсөлт 3 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 5 нэгж хувиар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний жин 4 нэгж хувиар өсчээ.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2015			2016			2017			Δ (2016/2015)			Δ (2017/2016)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		814	29%	859	35%	929	30%	44	5%	2%	70	8%	3%		
Түргэн эдэлгээтэй	640	465	16%	577	457	19%	624	518	17%	(8)	-2%	0%	61	13%	3%
Хүнс	270	318	11%	289	317	13%	280	361	12%	(1)	0%	0%	44	14%	2%
Эм, гариа	2	54	2%	2	63	3%	2	65	2%	9	17%	0%	2	3%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	368	93	3%	286	77	3%	342	92	3%	(16)	-17%	-1%	15	20%	1%
Удаан эдэлгээтэй	137	350	12%	102	402	16%	170	411	13%	52	15%	2%	9	2%	0%
Гутал, хувцас, цүнх	31	36	1%	38	38	2%	54	45	1%	2	6%	0%	6	17%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба төвлөг	62	70	2%	19	74	3%	64	65	2%	4	5%	0%	(9)	-12%	0%
Авто машин, түүний салбаз хэрэгсэл	1	196	7%	1	246	10%	1	252	8%	50	25%	2%	7	3%	0%
Бусад удаан эдэлгээтэй бараа	43	47	2%	45	44	2%	51	49	2%	(3)	-6%	0%	4	10%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн		1,097	38%	839	34%	1,196	38%	(257)	-23%	-9%	356	42%	15%		
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	14	566	20%	11	475	19%	20	751	24%	(90)	-16%	-3%	276	58%	11%
Суудлаас бусад пэвэрийн хэрэгсэл, эд анги	1	88	3%	0	139	6%	1	214	7%	51	59%	2%	74	54%	3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	13	478	17%	10	336	14%	19	537	17%	(142)	-30%	-5%	201	60%	8%
Барилгын материал	1,462	396	14%	597	227	9%	493	316	10%	(169)	-43%	-6%	89	39%	4%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	60	135	5%	40	137	6%	49	128	4%	2	1%	0%	(9)	-6%	0%
Аж үйлдвэрлэлийн орц		391	14%	390	16%	405	13%	(1)	0%	0%	16	4%	1%		
Хүнсний орц	34	22	1%	182	49	2%	32	15	0%	27	126%	1%	(34)	-69%	-1%
Химийн бүтээгдэхүүн	98	69	2%	86	60	2%	140	81	3%	(9)	-13%	0%	21	34%	1%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	12	11	0%	20	14	1%	30	16	1%	3	25%	0%	2	14%	0%
Цахилгаан эрчим хүч	1	95	3%	1	91	4%	2	100	3%	(4)	-4%	0%	8	9%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	1	0%	1	1	0%	1	1	0%	0	39%	0%	(1)	-58%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	613	192	7%	585	173	7%	631	193	6%	(19)	-10%	-1%	20	11%	1%
Нефтийн бүтээгдэхүүн		843	57%	733	35%	1,061	59%	(181)	-34%	-6%	239	67%	10%		
Дизель түлш	487	238	10%	371	164	7%	632	326	10%	(124)	-43%	-4%	162	98%	7%
АИ-92, АИ-95	261	172	6%	246	120	5%	276	162	5%	(52)	-30%	-2%	42	35%	2%
А-80 болон бусад	95	77	3%	116	72	3%	153	107	3%	(5)	-6%	0%	35	48%	1%
Бусад		16	1%	8	4	0%	109	6	0%	(14)	0%	0%	2	0%	0%
Нийт дүн		2,857		2,448		3,131		(409)	-14%		683	28%			

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2017 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	105.1	149%	(34.7)	-49%	70.4	8%
Түргэн эдэлгээтэй	20.6	34%	40.8	66%	61.4	13%
Удаан эдэлгээтэй	84.5	937%	(75.5)	-837%	9.0	2%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	363.0	102%	(6.9)	-2%	356	42%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	330.5	120%	(54.9)	-20%	275.6	58%
Барилгын материал	39.1	44%	50.3	56%	89.4	39%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	(6.6)	75%	(2.3)	25%	(8.9)	-6%
Аж үйлдвэрлэлийн орц	14.9		0.8		15.7	4%
Нефтийн бүтээгдэхүүн	178.2	75%	60.7	25%	238.9	67%
Дизель түлш	134.5	83%	27.0	17%	161.6	98%
АИ-92, АИ-95	17.5	41%	24.8	59%	42.3	35%
А-80 болон бусад	26.2	75%	8.8	25%	35.0	48%
Бусад	5.1	321%	(3.5)	-221%	1.6	0%
Нийт дүн	666.4	98%	16.4	2%	683	28%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд баатдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2017 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр импорт нь тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалаж 666.4 сая ам.доллараар өссөн бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 16.4 сая ам.доллараар тус тус өсчээ. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт нь тоо хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж 70.4 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 42%-иар өссөн нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Харин нефтийн бүтээгдэхүүний импортын хэмжээ 67%-иар өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2017 оны 9 дүгээр сарын байдлаар тонн тутамд 568 ам.доллар байв.